

1.ӨРХ, ХҮН АМ, НИЙГМИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

1.1 2014 оны жилийн эцсийн байдлаар манай аймаг 15891 хүн, үүнээс эрэгтэй 7937, эмэгтэй 7954 хүнтэй боллоо. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал хүн ам 1.3 хувиар, үүнээс эрэгтэй 2.1 хувиар, эмэгтэй 0.4 хувиар өссөн үзүүлэлттэй гарлаа. Нийт хүн амын 49.9 хувийг эрэгтэйчүүд, 50.1 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

Нийт хүн амын 32.5 хувийг 0-15 насны хүүхэд, 62.0 хувийг хөдөлмөрийн насны буюу 16-59 насны хүмүүс, 5.5 хувийг өндөр настнууд буюу 60 ба түүнээс насны хүмүүс эзэлж байна.

Тайлант онд 4749 өрх тоологдсон нь өмнөх оноос 1.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Шилжин ирсэн хүн 748 байгаа нь өмнөх оноос 8.4 хувиар буурч, шилжин явсан хүн 748 болж өмнөх оноос 4.6 хувиар өссөн байна. Шилжин ирэгсдийн 308 буюу 41.2 хувь нь Улаанбаатар хотоос, 134 буюу 17.9 хувь нь Дундговь аймгаас, 113 буюу 15.1 хувь нь Дорноговь аймгаас, 25.8 хувь нь бусад аймгаас ирсэн байна. Шилжин явагчдын 481 буюу 64.3 хувь нь Улаанбаатар хотруу, 82 буюу 11.0 хувь нь Дорноговь аймаг руу, 76 буюу 10.2 хувь Дундговь аймаг руу явсан байна.

Аймгийн хэмжээнд бүтэн өнчин хүүхэд 27, үүнээс эмэгтэй 11, хагас өнчин хүүхэд 177, үүнээс эмэгтэй 75 байгаа нь өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 8 хувийн өсөлттэй, хагас өнчин хүүхэд 7.3 хувиар буурсан үзүүлэлт гарчээ. Мөн өрх толгойлсон эцэг, эх 727 бүртгэгдсэн нь өмнөх оноос 8.2 хувиар буурсан байна. Ганц бие өндөр настан 162 байгаа нь өмнөх оноос 17.8 хувиар буурч, хөгжлийн бэрхшээлтэй иргэд 579 байгаа нь өмнөх оноос 3.9 хувиар өсөлттэй гарлаа.

2014 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 489 хүүхэд эхээс мэндэлсний 256 нь хүү, 233 нь охин байлаа. Нийт 110 хүн нас барсан байна. Бүртгүүлсэн гэр бүл 62, цуцалсан гэр бүл 20, үрчлэгдсэн хүүхэд 8 бүртгэгдлээ. Төрөлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.8 хувиар буурч, нас баралт 110 байгаа нь өмнөх оноос

29.4 хувиар өссөн байна. Бүртгүүлсэн гэр бүл өмнөх оноос 10.2 хувиар, цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оноос 25.9 хувиар тус тус буурсан байна.

Харин үрчлэгдсэн хүүхдийн тоо 8 байгаа нь өмнөх оны мөн үеийн үзүүлэлттээс 14.3 хувиар өссөн байна.

2014 онд хөдөлмөрийн насны хүн ам 9850, үүнээс 5238 нь ажиллагчид байгаа нь 53.2 хувийг эзэлж байна.

Хүн амын тоог сумдаар мэдээлбэл:

Сумд		2013 он	2014 он	Өсөлт Бууралт	Хувь
Баянтал	Нийт хүн ам	1048	1084	36	3.4
	Эрэгтэй	534	548	14	2.6
	Эмэгтэй	514	563	49	9.5
Сүмбэр	Нийт хүн ам	11570	11609	39	0.3
	Эрэгтэй	5667	5761	94	1.7
	Эмэгтэй	5903	5848	-55	-0.9
Шивээ- говь	Нийт хүн ам	3076	3198	122	4.0
	Эрэгтэй	1571	1628	57	3.6
	Эмэгтэй	1505	1570	65	4.3
Дүн	Нийт хүн ам	15694	15891	197	1.2
	Эрэгтэй	7772	7937	165	2.1
	Эмэгтэй	7922	7954	32	0.4

2014 оны жилийн эцсийн суурин хүн амын тоог
насны бүлэглэлээр үзүүлбэл:

Насны бүтэц	Аймгийн дүн	Баянтал сум	Сүмбэр сум	Шивээговь сум
0-4.	2095	146	1491	458
5-9.	1599	107	1166	326
10-14.	1200	80	875	245
15-19	1391	98	1027	266
20-24	1445	91	1067	287
25-29	1620	106	1164	350
30-34	1314	84	931	299
35-39	1154	90	845	219
40-44	1078	65	815	198
45-49	882	60	654	168
50-54	741	53	544	144
55-59	495	49	352	94
60-64	296	19	222	55
65-69	193	10	146	37
70-74	169	12	127	30
75-79	119	9	96	14
80-84	54	2	47	5
85-89	33	2	28	3
90-94	13	1	12	-
95-99	-	-	-	-
100+	-	-	-	-
Нийт	15891	1084	11609	3198

Насны бүлэглэлээс харахад 70 ба түүнээс дээш настан 388, 80 ба түүнээс дээш настан 100, аймгийн хамгийн өндөр настан нь Баянтал сумын 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт амьдарч байна.

Өрхийн тоог сумдаар үзүүлбэл:

Сумд	Он		Өсөлт бууралт	Хувь
	2013	2014		
Баянтал	318	331	13	4.1
Сүмбэр	3390	3423	33	1.0
Шивээговь	972	995	23	2.4
Дүн	4680	4749	69	1.5

Нийт өрхийг байршлаар нь авч үзвэл:

Аймгийн төвд 2823 өрх буюу нийт өрхийн 59.4 хувь

Сумын төвд 826 өрх буюу нийт өрхийн 17.4 хувь

Хөдөө багт 1100 өрх буюу нийт өрхийн 23.2 хувь нь тус тус амьдарч байна.

2014 онд тоологдсон 4749 өрхийг сууцны төрлөөр нь авч үзвэл:

- Гэрт амьдардаг өрх 1860
- Байшинд амьдардаг өрх 2884
 - Орон сууцанд амьдардаг өрх 1926
 - Бие даасан тохилог сууцанд амьдардаг өрх 7
 - Сууцны тусдаа байшинд амьдардаг өрх 795
 - Нийтийн байранд амьдардаг өрх 156
- Бусад сууцанд амьдардаг өрх 5 байна.

1.2. Жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр бүтэн өнчин хүүхэд 27 байгаагийн 11 нь эмэгтэй. Хагас өнчин 177 хүүхэд байдгаас 0-4 настай 14, 5-9 настай 34, 10-14 настай 61, 15-17 настай хүүхэд 68 байна. Хагас өнчин хүүхдийн 75 нь буюу 42.4 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Өмнөх оны мөн үеэс бүтэн өнчин хүүхэд 8 хувиар өсч, хагас өнчин хүүхэд 7.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд 579 бүртгэгдсэнээс эмэгтэй 258, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй 202 бүртгэгдсэн нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд өмнөх оноос 3.9 хувиар өссөн мэдээтэй байна. Нийт хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс 0-14 насны 30 хүүхэд байна.

2014 онд ганц биеэрээ амьдарч байгаа өндөр настан өрхийн тоо 162 бүртгэгдсэн ба үүнээс 60 ба түүнээс дээш настай /эрэгтэй/ 34 , 55 түүнээс дээш настай /эмэгтэй/ 128 өндөр настан амьдарч байна.

Аймгийн хэмжээнд өрх толгойлсон эмэгтэй 603 амьдарч байгаа нь өмнөх оноос 6.6 хувиар буурсан байна.

Үүний: 247 нь буюу 41 хувь нь 3 хүртэл хүүхэдтэй

306 нь буюу 50.7 хувь нь 3-5 хүүхэдтэй

50 нь буюу 8.3 хувь нь 6-аас дээш хүүхэдтэй хүмүүс байлаа.

1.3. Хүн амын амьжиргааны доод түвшнээс доогуур орлоготой өрхийн зарим үзүүлэлтүүдийг тайлант оны байдлаар авч үзвэл (Тайлант онд АДТүвшин Төвийн бүсэд 149700 төгрөг байлаа.)

Ядуу өрх 376 , өрхийн гишүүд 1599 байгаа нь нийт өрхийн 7.9 хувийг, нийт хүн амын 10.1 хувийг эзэлж байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс ядуу өрхийн тоо 8.9 хувиар, иргэд 7.4 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Нийт ядуу өрхөөс нэн ядуу өрх 153, өрхийн гишүүд нь 687 байгаа нь нийт ядуу өрхийн 40.7 хувийг, ядуу өрхийн гишүүдийн 42.9 хувийг эзэлж байгааг өмнөх оны мөн үетэй харьцуулбал ядуу өрх 11.1 хувиар, өрхийн гишүүд 10.2 хувиар буурсан байна.

Ядуу иргэдийн 16.1 хувь нь боловсролгүй, 22.7 хувь нь ЕБС-д суралцагсад байна. Энэ онд орон гэргүй ядуу өрх 13 бүртгэгдсэний 76.9 хувь нь нэн ядуу өрх байлаа. Аймгийн хэмжээгээр ядуу өрхүүдэд 5.2 сая.төгрөгийн

мөнгөн тусламж, 11.8 сая төгрөгийн бусад тусламжийг олгосон байна.

1.4. Жилийн эцсийн байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 382 байгаагаас 225 эмэгтэй байгаа нь нийт ажилгүй иргэдийн 58.9 хувийг эзэлж байна.

Мөн хугацаанд нийт 280 хүн байнгын шинэ ажлын байраар хангагдсан байна. Үүний 127 нь буюу 45.3 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна. Ажил идэвхтэй хайгч иргэдийг боловсролын түвшингээр нь авч үзвэл боловсролгүй иргэд 9 үүнээс эмэгтэй 4, бага боловсролтой 18 үүнээс эмэгтэй 8, суурь боловсролтой 36 үүнээс эмэгтэй 22, бүрэн дунд 149 үүнээс эмэгтэй 82, техникийн болон мэргэжлийн 29 үүнээс эмэгтэй 11, тусгай мэргэжлийн дунд 42 үүнээс эмэгтэй 30, дипломын болон бакалаврын дээд 95 үүнээс эмэгтэй 64, магистр болон доктор 4 үүнээс 4 эмэгтэй байна. Нийт ажилгүй иргэдийн 39.0 хувь нь бүрэн дунд боловсролтой, 25.9 хувь нь бакалавр, түүнээс дээш боловсролтой иргэд байна.

Жилийн эцсийн байдлаар ажлын байрны захиалга 455 ирж, аймгийн Хөдөлмөрийн хэлтсээр 280 иргэн ажилд зуучлуулсны 127 нь эмэгтэйчүүд байлаа.

1.5. Тайлант онд халамжийн хэлтсээс давхардсан тоогоор 4606 хүнд 1281.0 сая төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж хөнгөлөлт, халамж үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад үйлчилгээ авсан иргэдийн тоо 20.2 хувиар, тэтгэмж болгон олгосон мөнгөн дүн 36.4 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Халамжийн сангийн мэдээг хүснэгтээр харуулбал:

Үзүүлэлт	Хамрагдсан иргэдийн тоо		Олгосон мөнгөн дүн /сая.төг/	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Халамжийн тэтгэвэр	899	340	959.9	391.4
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	910	308	138.5	243.2
Нөхцөлт мөнгөн тусламж	156	252	15.1	76.9
Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамж үйлчилгээ	51	61	26.2	10.8
Алдарт эхийн одонтой эхчүүдийн тусламж	1097	1130	151.8	159.7
Ахмад настны хөнгөлөлт	796	1439	247.9	81.6
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөнгөлөлт	491	265	51.2	57.9
Жирэмсэн амаржсаны тэтгэмж	1253	793	379.6	237.9
Алдар цолтой ахмад настны тэтгэмж	123	18	45.4	22.3
Бүгд	5776	4606	2015.6	1281.7

2. ХӨДӨӨ АЖ АХУЙ

2.1. 2014 оны жилийн эцсээр манай аймаг 339.4 мянган толгой малтай болсон нь өмнөх оноос 24.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Үүнээс:Тэмээ 872 толгой, адуу 14968 толгой, үхэр 10358 толгой, хонь 152260 толгой, ямаа 160980 толгой тус тус тоологджээ.

Малын төрөл	Сумд			ДҮН
	Баянтал	Сүмбэр	Шивээговь	
Тэмээ	171	611	90	872
Адуу	3395	10192	1381	14968
Үхэр	1594	7363	1401	10358
Хонь	25168	109135	17957	152260
Ямаа	22915	118002	20063	160980
Бүгд	53243	245303	40892	339438

Аймгийн хэмжээнд 950 малтай өрх байгаагаас 640 малчин өрхийн 3381 ам бүлийн гишүүд тоологдсон ба нийт малчид 1122, үүнээс эмэгтэй малчид 509 буюу нийт малчдын 45.4 хувийг эзэлж байна

Нийт малчдыг насны бүлгээр нь авч үзвэл :

15-34 нас - 377 малчин буюу 33.6 хувь

35-59 нас - 596 малчин буюу 53.1 хувь

60 аас дээш насны - 149 малчин буюу 13.3 хувийг тус тус эзэлж байна.

Эрлийз, цэвэр үүлдрийн мал 3444, үүнээс “Сүмбэр” хонь 1166 толгой Сүмбэр - Монгол эрлийз хонь 839 толгой тоологдлоо .

Нийт малын дүнд тэмээ 0.3 хувь, адуу 4.4 хувь, үхэр 3.1 хувь, хонь 44.9 хувь, ямаа 47.3 хувийг эзэлж байна.

Малын тоо (толгойгоор)

Малын төрөл	2013 он	2014 он	Хувь	Зөрүү
Толгойн тоогоор	272764	339438	24.4	66674
Тэмээ	821	872	6.2	51
Адуу	12122	14968	23.5	2846
Үхэр	7697	10358	34.6	2661
Хонь	120953	152260	25.9	31307
Ямаа	131171	160980	22.7	29809

2.2 2014 онд малтай өрх 950 бүртгэгдсэн бөгөөд энэ онд манай аймгаас 80 мянгат малчин төрлөө. Өмнөх онтой харьцуулбал 45.5 хувиар нэмэгдсэн байна.

Үүнд:

Сүмбэр сумын мянгат малчин	54
Баянтал сумын мянгат малчин	20
Шивээговь сумын мянгат малчин	6

Мянгат малчдаас хамгийн их малтай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир /3245 толгой мал/, хамгийн их тэмээтэй Сүмбэр сумын 6 дугаар багийн иргэн З.Бадарч /105 толгой /, хамгийн их адуутай нь Баянтал сумын 2 дугаар багийн иргэн Л.Батнасан /404 толгой /, хамгийн их үхэртэй нь Сүмбэр сумын 4 дугаар багийн иргэн М.Батсайхан /205 толгой /, хамгийн их хонь, ямаатай нь Сүмбэр сумын 4 дүгээр багийн иргэн Д.Эрдэнэ-Очир /1800 толгой хонь, 1340 толгой ямаа / нар байлаа.

Малтай өрхийн малын тоог бүлэглэлтээр авч үзвэл:

10 хүртэл толгой малтай	2
11-30 толгой малтай	86
31-50 толгой малтай	79
51-100 толгой малтай	116
101-200 толгой малтай	148
201-500 толгой малтай	278
501-999 толгой малтай	139
1000-1499 толгой малтай	61
1500-2000 толгой малтай	11
2001 түүнээс дээш толгой малтай	9 өрх байна.

2.3 2014 онд аймгийн хэмжээнд төллөвөл зохих эх малын 94.5 хувь буюу 117991 мал төллөж гарсан төл 120483, үүнээс 3187 төл хорогдож, 117296 төл бойжиж байна.

Бойжсон төлийг төрлөөр нь авч үзвэл:

Сумд	Төллөвөл зохих хээлтэгч	Төллөсөн хээлтэгч	Төллөлтийн хувь	Хорогдсон төл	Бойжсон төл
Баянтал	18701	19450	104.0	74	20014
Сүмбэр	92443	84693	91.6	3113	82848
Шивээ-говь	13758	13848	100.6	0	14434
Дүн	124902	117991	94.5	954	117296

2013 онд 3135 төл хорогдсон бол 2014 онд 3187 төл хорогдож өмнөх оны мөн үеэс 1.7 хувиар өссөн ба нийт хорогдсон төлийн 60.0 хувийг ишиг, 37.0 хувийг хурга эзэлж байна.

2.4. 2014 оны жилийн эцсийн байдлаар 1642 том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны том малын хорогдлоос 10.2 хувиар буурсан байна.

Малын зүй бус хорогдол /толгой/

Он	Бүгд	Үүнээс:				
		Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
2010	15316	6	265	171	5993	8881
2011	314	8	15	8	171	112
2012	853	5	21	19	335	473
2013	1826	3	23	21	677	1104
2014	1642	38	49	70	595	890

Малын зүй бус хорогдлыг сумдаар үзүүлбэл:

Сумд	Хорогдсон том мал		Оны эхний малд эзлэх хувь	
	2013 он	2014 он	2013 он	2014 он
Баянтал	515	79	1.5	0.1
Сүмбэр	1184	1466	0.7	0.6
Шивээговь	127	97	0.5	0.2
Дүн	1826	1642	0.8	0.3

2.5. Оны эцэст 154.8 мянган хээлтэгч мал байгаа нь өмнөх оны хээлтэгч малаас 24.0 хувиар буюу 29.9 мянган толгойгоор өсчээ.

Хээлтэгч малыг өмнөх онтой харьцуулбал: /толгой/

Сумд	Он		Зөрүү	Хувь
	2013	2014		
Баянтал	18701	24990	6289	33.6
Сүмбэр	92443	112553	20110	21.8
Шивээ- говь	13758	17278	3520	25.6
Дүн	124902	154821	29919	24.0

2.6. Аймгийн дүнгээр цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн 3444 толгой мал тоологдсон бөгөөд цэвэр үүлдэр, эрлийз, нутгийн шилмэл омгийн малыг төрлөөр нь ангилбал:

- Цэвэр үүлдрийн “ Сүмбэр “ 1166 толгой
 - Сүмбэр Монгол эрлийз 839 толгой
 - Бусад үүлдэр 1439 толгой
- тус тус тоологдсон байна .

2.7. Ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлийн эцсийн мэдээнээс харахад 2014 онд аймгийн хэмжээнд төмс 56.31 тонн, хүнсний ногоо 68.3 тонн нийт 124.6 тонн ургац хураасан байна . Мөн тэжээлийн ургамал 2.4 тонн хурааснаас ногоон тэжээл 1.9 тонн , олон наст 0.5 , бэлтгэсэн өвс 947.8 тн, гар тэжээл 65.9 тн хураан авсан байна. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад хураасан төмс 51.9 хувиар, хүнсний ногоо 56.8 хувиар , бэлтгэсэн өвс 18.9 тус тус өссөн үзүүлэлттэй байна.

дд	Үзүүлэлт	2013 он	2014 он	Өсөлт бууралт
1	Хураасан төмс	27.1	56.31	29.21
2	Хураасан хүнсний ногоо	29.45	68.27	38.81
3	Хураасан тэжээлийн ургамал	23.75	2.4	-21.35
4	Бэлтгэсэн өвс	768.8	947.8	179
5	Гар тэжээл	48.4	65.9	17.5
6	Нийт тариалсан талбай / га /	23.49	24.22	0.73

2.8. Хүн ам , мал , хөдөө аж ахуйн тэжээвэр амьтдын 2014 оны тооллогын дүнгээс үзэхэд аймгийн дүнгээр гахай, тахиа 1076 тоологдлоо.

Нийт 326 гахай үүнээс:

хээлтэгч	102
хээлтүүлэгч	16
бусад	208

Нийт 750 тахиа үүнээс:

үндсэн эх	696
хээлтүүлэгч	29
бусад	25

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гахай 37.0 хувиар өсч, тахиа 5.8 хувиар буурсан байна.

3. АЖ ҮЙЛДВЭР, БАРИЛГА

3.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтийн мэдээг ШОНУ, Ус-Ду, Тохижилт-Сүмбэр, Талын илч, Илчлэг-шивээ, Илчит сансар, Чойр хайрхан зэрэг томоохон аж ахуйн нэгж байгууллагуудаас авдаг. 2014 оны жилийн эцсийн байдлаар эдгээр аж ахуйн нэгж байгууллага нь 39.5 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 37.6 тэр бум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Шивээ-Овоо Хувьцаат компани нь аймгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 96.7 хувийг, нийт борлуулалтын 96.5 хувийг гүйцэтгэсэн байна.

Шивээ-Овоо хувьцаат компани нь зах зээл дээр 1 тонн нүүрсийг 21210 төгрөгөөр худалдаалж байна.

Шивээ-Овоо хувьцаат компаний борлуулалтын үзүүлэлтийг танилцуулбал:

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилийн эхнээс гүйцэтгэл	
		2013 он	2014 он
Бүтээгдэхүүн борлуулалт /үнийн дүнгээр/	Сая.төг	31242.6	36326.1
Нүүрс борлуулалт /биет хэмжээ/	Мян.тн	1925.7	2012.1
Нүүрс гаргалт /биет хэмжээ/	Мян.тн	1964.4	1929.8
Нийт бүтээгдэхүүн /үнийн дүнгээр/	Сая.төг	31870.4	38176.1
Ажиллагсдын тоо	Хүн	495	495

ШОНУурхайн үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал:

- Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт мөнгөн дүнгээр 19.8 хувиар,
- Бүтээгдэхүүн борлуулалт мөнгөн дүнгээр 16.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна

3.2 Аймгийн хэмжээний төв суурин газруудад халаалт, халуун хүйтэн ус үйлдвэрлэх, бохир татан зайлуулах чиглэлээр Ус Ду, Талын Илч, Илчлэг Шивээ , Илчит сансар зэрэг ОНӨҮГ-ууд үйл ажиллагаа явуулж байна. 2014 онд ус дулааны эдгээр байгууллагууд нь нийт 1297.6 сая.төгрөгийн үйлдвэрлэл явуулсан бөгөөд үүнээс 1097.7 сая.төгрөгийн хэрэглээний халуун ус үйлдвэрлэн, 129.6 сая.төгрөгийн цэвэр ус түгээж, 70.3 мян.төгрөгийн бохирыг татан зайлуулсан байна.

3.3 2014 онд барилгын салбараас 8 аж ахуйн нэгж байгууллага сонгогдон мэдээнд хамрагдсан байна. Хаппи бьюлдинг ХХК хонхор хотхоны 4-р байрны гадна фасадын ажил 240.7 сая төгрөгийн өртөгтэй , Их даян бүүвэй ХХК 7-р байрны фасад 206.3 сая төгрөгийн өртөгтэй, зам талбайн засварын ажил 100.0 сая төгрөгийн өртөгтэй, Имплоир ХХК 5-р Сургуулийн гадна талбайн тохижилтын ажлыг 69.6 сая төгрөгийн өртөгтэй, Эко дэнж ХХК эко сүмбэр хотхоны 7-р байрны ажлыг 40.0 сая төгрөгийн өртөгтэй, Хөвсгөл аяны жолоо ХХК нийгмийн даатгал хэлтсийн байрыг 675.4 сая төгрөгийн өртөг бүхий ажлуудыг тус тус хийж хүлээлгэн өгсөн байна.

Түмэн зүг ХХК Ганзам хотхон барих ажил 100.0 сая төгрөгийн, Эко дэнж ХХК Залуус хотхоны 3-р байрны ажил 15.0 сая төгрөгийн, Зос трейд ХХК Онцгой байдлын хэлтсийн барилгын ажил 1597.8 сая төгрөгийн, Оточ ноёдууд ХХК 1-р цэцэрлэгийн өргөтгөлийн ажил 400.0 сая төгрөгийн төсөвт ажлууд гүйцэтгэлийн шатандаа явж байна .

4. ТӨСӨВ САНХҮҮ, БАНК

4.1. 2014 оны жилийн эцсийн байдлаар орон нутгийн төсвийн орлого 17367.3 сая төгрөг буюу 92.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэлийг танилцуулбал:

	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Нийт орлого	18818.8	17367.4
Хөрөнгийн орлого	-	0.2
1.Урсгал орлого	4129.7	4635.9
Татварын орлого	3824.1	4178.6
Татварын бус орлого	305.6	457.3
2.Тусламжийн орлого	14689.1	12731.3

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд орлогын биелэлт 92.3 хувь, урсгал орлогын биелэлт 112.3 хувь, тусламжийн орлогын биелэлт 86.7 хувьтай, хөрөнгийн орлого 0.2 сая төгрөгийн орлоготой байна.

Оны эцсийн байдлаар аймгийн хэмжээгээр 17557.3 сая төгрөгийн зарлага санхүүжилт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10.9 хувиар өссөн байна.

Төсвийн зарлагын 2014 оны гүйцэтгэлийг танилцуулбал:

	Төлөвлөгөө /сая.төг/	Гүйцэтгэл /сая.төг/
Бүх зардал	20665.6	17557.3
Урсгал зардал	12617.7	10996.6
Хөрөнгийн зардал	8047.9	6560.7
Байгууллагын тоо	47	47
Ажиллагсадын тоо	751	751

Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд төсвийн зардал 15.0 хувийн хэмнэлттэй байна.

Төсөвт байгууллагын өглөг, авлагын мэдээгээр:

Өглөгийн үлдэгдэл 14.7 сая төгрөг

Авлагын үлдэгдэл 11.7 сая төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өглөг 74.4 хувиар, авлага 42.6 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

4.2. Говьсүмбэр аймагт үйл ажиллагаа явуулж буй банкуудын салбарын эдийн засгийн үйл ажиллагааг 2014 оны эцсийн байдлаар танилцуулъя.

Банкуудын эдийн засгийн үзүүлэлт:

/өссөн дүнгээр/

дд	Үзүүлэлт	хн	Банкууд			Дүн
			Төрийн банк	ХААН банк	Хас банк	
1	Салбар үйлчилгээний цэг	тоо	5	5	2	12
2	Цахим банкны үйлчилгээний хэрэглэгчид	хүн	4406	11467	8314	24187
3	Нийт ажиллагсад	хүн	31	31	14	76
4	Үүнээс : зээлийн эдийн засагч	хүн	6	8	4	18
5	Хадгаламж эзэмшигчид	хүн	3040	3225	5915	12180
6	Хадгаламжийн хэмжээ	сая. төг	2757.2	2799.8	2877	8434
7	Хадгаламжийн бүтээгдэхүүн	тоо	10	44	8	62
8	Хадгаламжийн дундаж хүү	хувь	1.2	1.1	1.05	1.1
9	Зээлийн бүтээгдэхүүн	тоо	14	13	14	41
10	Зээлийн дундаж хүү	хувь	1.6	1.6	1.5	1.6

11	Зээл авсан : ААНБ	тоо	2	8	13	23
12	Иргэд	хүн	2234	3061	1857	7152
13	Малчид	хүн	93	235	0	328
14	Зээл олгосон : ААНБ	сая.т өг	20.5	356.1	1065	1441.6
15	Иргэд	сая.т өг	8373.5	23362.9	7964	39699.9
16	Малчид	сая.т өг	313.2	953.9	0	1267.1
17	Зээлийн эргэн төлөлт	хувь	100.0	99.8	99.9	99.9
18	Харилцахын тоо	тоо	6909	23414	2401	32724.0
19	Харилцахын дүн	сая.т өг	1730.9	1777.1	360.0	3868.0
20	Карт эзэмшигчдийн тоо	хүн	8221	14078	3621	25920
21	Карт эзэмшигчдэд олгох хүүгийн хэлбэр	хувь	3.2	3.6	3.0	3.3
22	АТМ-н тоо	тоо	3	3	1	7

Банкны эдийн засгийн үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал хадгаламж эзэмшигчдийн тоо 1339-өөр буюу 11.0 хувиар өсөж, хадгаламжийн хэмжээ 436.1 сая төгрөгөөр буюу 4.9 хувиар буурсан бол, зээл авсан аж ахуйн нэгжийн тоо 4-өөр буюу 17.3 хувиар, аж ахуй нэгж байгууллагад олгосон зээлийн хэмжээ 5740.7 сая төгрөгөөр буюу 5.0 дахин өссөн, зээл авсан иргэдийн тоо 973-аар буюу 13.6 хувиар, иргэдэд олгосон зээлийн хэмжээ 7850.1 сая төгрөгөөр буюу 19.8 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байлаа.

5. НИЙГМИЙН ДААТГАЛ, БУСАД ДААТГАЛУУД

5.1 Тус хэлтсийн жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 7580.0 сая төгрөг, зарлага 7617.4 сая төгрөгөөр тус тус төлөвлөгдсөн бөгөөд нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 7080.0 сая төгрөгөөр буюу 93 хувиар биелж, зарлага 7524.7 сая төгрөг буюу 98 хувьтай гарлаа.

2014 онд нийт давхардсан тоогоор 2284 хүнд 5498.0 сая төгрөгийн тэтгэвэр, 2078 хүнд 727.9 сая төгрөгийн тэтгэмж, 27300 хүнд 1255.5 сая төгрөгийн хөнгөлөлттэй эмнэлэг, эмийн сангийн санхүүжилтийг цаг хугацаанд нь бүрэн олгожээ.

Дундаж цалингийн судалгаа, 12 дугаар сарын байдлаар, мянган төгрөгөөр

ДД	Хариуцлагын хэлбэр	Даатгуулагчид	ААНБ	Цалин сан	Дундаж цалин
1	ХК- Хувийн	28	4	79160.0	235.6
2	ХК- Төрийн	623	2	7158019.5	957.5
3	ХХК-Хувийн	650	79	1781120.1	228.3
4	ХХК-Төрийн	111	4	600969.4	451.2
5	ХХК-Гадаадын	222	3	736011.4	276.3
6	УҮГ-Төрийн өмчийн оролцоотой	1163	17	10658919.5	763.8
7	УҮГ-ОН-ийн өмчийн оролцоотой	319	6	651959.5	170.3
8	Төсөвт	1512	55	9592158.8	528.7
9	Төсөвт-Цэрэг цагдаа	282	5	2119611.1	626.4
10	ТББ	100	15	340244.0	283.5
11	Нөхөрлөл-ЗГБХ	96	7	318913.4	276.8
12	Хоршоо	4	2	6990.0	145.6
13	ХЭАА	25	4	57672.6	192.2
14	Сайн дурын даатгуулагч	705	0	1031325.2	121.9
15	Патенттай иргэн	6	2	6360.0	88.3
	ДҮН	5846	205	35139435	500.9

5.2 Говьсүмбэр аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Монгол даатгал, Ард даатгалын компаниудаас жилийн эцсийн байдлаар мэдээг авч танилцуулбал :

дд	Даатгалын бүтээгдэхүүний төрөл	/сая төгрөг/	
		2014 оны жилийн эцэс	
		Орлого	Олгосон нөхөн төлбөр
1	Тээврийн хэрэгслийн даатгал	34115.5	17783.6
2	Жолоочийн хариуцлагын даатгал	82109.0	25099.4
3	Эд хөрөнгийн даатгал	5517.1	1131.0
4	Хөдөлмөрийн чадвар түр алдалтын даатгал	25820.3	17362.0
5	Гэнэтийн ослын даатгал	25523.8	1434.5
6	Мэргэжлийн хариуцлагын даатгал	1344.4	0
7	Ачаа тээвэрлэлтийн даатгал	9332.1	0
8	Нийтийн ба хувийн сууцны даатгал	2083.5	0
9	Гэр хашаа байшингийн даатгал	885,0	175.0
10	Лангуу түрээслэгч жижиглэн худалдаа эрхлэгчдийн даатгал	419.8	0
11	Хүүхдийн гэнэтийн ослын даатгал	2737.0	390
12	Нийт	189887.5	63375.5

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад даатгалын нийт орлого 19.5 хувиар , олгосон нөхөн төлбөр 27.2 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

6. ТЭЭВЭР, ХОЛБОО, ГАЗАР

6.1 Аймгийн хэмжээнд хот доторхи такси үйлчилгээнд “Чойр такси ХХК”, хот хоорондын такси үйлчилгээнд “Их

боржигон зам” хоршоо хот хоорондын тээврийн үйлчилгээгээ үзүүлж байна.

Тээвэр, авто замын газрын мэдээг харуулбал:

/өссөн дүнгээр/

	Хэмжих нэгж	2013 он	2014 он
Зорчигч эргэлт	мян.хүн.км	2930.6	3359.0
Тээвэрлэсэн зорчигч	мян.хүн	12.2	14.0
Тээврийн орлого	мян.төг	7058.7	8044.5
Ажиллагчдын тоо	хүн	9	8

Тээвэр, авто замын газрын мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал зорчигч эргэлт 14.6 хувиар, тээсэн зорчигч 14.8 хувиар, тээврийн орлого 14.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна .

Авто тээврийн үндэсний төвийн Говьсүмбэр аймаг дахь салбарын мэдээгээр 2014 оны байдлаар 2847 тээврийн хэрэгсэл бүртгэгдсэний 2626 нь хувийнх, 562 нь албан байгууллагын тээврийн хэрэгсэл байна.

Д Д	Тээврийн хэрэгслийн төрөл	Бүртгэгдсэн тээврийн хэрэгслийн тоо					
		2013 он			2014 он		
		Сүмбэр	Баян-тал	Шивээ-говь	Сүмбэр	Баян-тал	Шивээ-говь
1	Бүгд	2612	65	199	2616	56	175
2	Суудлын	1341	30	90	1413	25	70
3	Автобус	90	0	15	83	0	12
4	Тусгай зориулалтын	128	0	8	134	1	14
5	Мотоцикл	159	9	18	181	10	19
6	Механизм	63	0	1	42	0	3
7	Чиргүүл	192	1	8	159	0	11
8	Ачааны автомашин	639	25	59	604	20	46

Тээврийн хэрэгслийн насжилт

Сумд	Тээврийн хэрэгслийн насжилт / жил /			
	0-3 жил	4-10 жил	11 ба түүнээс дээш жил	Бүгд
Сүмбэр	184	461	1971	2616
Баянтал	7	5	44	56
Шивээговь	19	29	127	175
Нийт дүн	210	495	2142	2847

6.2 2014 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 575 өрх суурин болон модем хэлбэрээр интернет хэрэглэж байгаа нь аймгийн нийт өрхийн 12.1 хувийг эзэлж байна. Интернеттэй өрхийн нийт гишүүд 1928 байгаа нь хүн амын 12.1 хувийг эзэлж байна.

дд	Үзүүлэлт		Бүгд	Багууд					
				1	2	3	4	5	6
1	Интернэт хэрэглэгч өрх	Суурин	402	263	47	84	1	7	0
		Модем	173	79	52	42	0	0	0
	Дүн		575	342	99	126	1	7	0
2	Өрхийн гишүүд	Суурин	1268	873	151	210	2	32	0
		Модем	660	304	251	105	0	0	0
	Дүн		1928	1177	402	315	2	32	0

Аймгийн холбооны газрын 2014 оны мэдээгээр :

Үйлчилгээний нийт орлого 224.7 сая төгрөг, үүнээс хүн амаас орсон орлого 134.8 сая төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс нийт орлого, хүн амаас орсон орлого 20.2 хувиар тус тус өссөн байна. 2014 онд 195 цахилгаан мэдээ дамжуулсан нь өмнөх оны мөн үеэс 3.2 дахин буурсан байна. Аймгийн хэмжээгээр КТВ суваг 1296 байна. Телефон цэгийн тоо 403 байгаа нь өмнөх оны мөн үетэй адил түвшинд байна, харин айл өрхөд 292 цэг ашиглагдаж байгаа нь өмнөх оны мөн үеэс 24.6 хувиар өссөн байна.

6.3 Газрын харилцаа, Барилга хот байгуулалтын газрын мэдээгээр манай аймгийн нийт газар нутгийн хэмжээ 554.2 мян.га байдаг бөгөөд нийт талбайн:

68.0 хувийг Сүмбэр сум

16.5 хувийг Баянтал сум

15.5 хувийг Шивээговь сум эзэлж байна.

Нийт газрын :

87.0 хувийг- Хөдөө аж ахуйн газар

1.1 хувийг -Хот, тосгон, суурин газар

0.9 хувийг -Зам шугам сүлжээний газар

0.3 хувийг -Усан сангийн газар

10.8 хувийг- Улсын тусгай хэрэгцээний газар тус тус

эзэлдэг

Газрын ангилал	хн	Он	
		2013	2014
НИЙТ ГАЗАР	га	554180	554180
Үүнээс: ХАА-н газар	га	482241.0	481658.6
Хот тосгон, суурин газар	га	5955.1	6023.6
Зам шугам сүлжээний газар	га	4784.1	5298.0
Ойн сан бүхий газар	га	-	-
Усны сан бүхий газар	га	1538.0	1538.0
Улсын тусгай хэрэгцээний газар	га	59661.8	59661.8

Тайлант жилд нийт газрын 6.5 хувьд хохирол учирсан байна. Үүнээс Бэлчээр ба бусад суурин газарт 35487 га буюу хохирол учруулсан газрын 98.5 хувийг , Хот тосгон бусад суурин газарт 488.4 буюу 1.4 хувь, усны сан бүхий газарт 5.2 га буюу 0.01 хувь , ухаж эвдэрсэн газарт 38.7 га буюу 0.1 хувийг тус тус эзэлж байна.

Газрын төлбөр төлөлт, ноогдуулалтанд 94.4 сая төгрөгийн төлбөр төлөгдсөн нь өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар буурсан үзүүлэлт гарлаа.

2014 оны жилийн эцсийн байдлаар 5661 иргэнд 733.9 га газрыг гэр бүлийн хэрэгцээнд нэг удаа үнэгүй

өмчлүүлсэн. 0.17 га газрыг аж ахуйн зориулалтаар давуу эрхээр худалдан авсан байна.

7. АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГА

Аймгийн татварын хэлтсийн бүртгэлээр 2014 онд 417 байгууллага үйл ажиллагаа явуулсан байна.

Дээрх аж ахуйн нэгж байгууллагыг хариуцлагын хэлбэрээр нь авч үзвэл:

▪ ХК	2
▪ ХХК	199
▪ ББН	4
▪ ЗБН	8
▪ Хоршоо	12
▪ Хадгаламж зээлийн хоршоо	1
▪ ОНӨҮГ	5
▪ Салбар байгууллага	60
▪ Төсөвт байгууллага	55
▪ ТББ	45
▪ Сан	7
▪ Бусад /Шашин-5, ОНБ 14/	19

Өмнөх оны мөн үетэй харьцуулбал аж ахуй нэгж байгууллага 15.3 хувиар нэмэгдсэн байна.

8. БОЛОВСРОЛ

8.1 2014 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 992 оюутан байгаагийн 499 буюу 50.3 хувь нь эмэгтэй оюутнууд эзэлж байна. Их дээд сургуульд 848 оюутан суралцаж байгаагаас эмэгтэй 449 буюу 52.9 хувийг, Коллежид нийт 132 байгаагаас эмэгтэй 51 буюу 38.6 хувийг, МСҮТ-д нийт 12 оюутан суралцаж буйгаас эмэгтэй 6 буюу 50.0 хувийг эмэгтэйчүүд эзэлж байна.

8.2 2014-2015 оны хичээлийн жилийн байдлаар аймгийн хэмжээнд төрийн өмчийн 5 цэцэрлэг, хувийн өмчийн 5 цэцэрлэг нийт 10 цэцэрлэгийн 46 бүлэгт 1516 хүүхэд байгаагаас 191 малчдын хүүхэд хамрагдан хүмүүжиж байна. Цэцэрлэгийн бүлгийг тоогоор нь авч үзвэл яслийн

бүлэг 3, бага бүлэг 8, дунд бүлэг 6, ахлах бүлэг 6, бэлтгэл бүлэг 6, холимог бүлэг 9, ээлжийн бүлэг 4, нүүдлийн бүлэг 4 байна.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагад 162 ажиллагсад байгаагаас 146 нь буюу нийт ажиллагсадын 90.1 хувь нь эмэгтэй ажиллагсад байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Эрхлэгч 10
- Арга зүйч 1
- Үндсэн багш 43
- Туслах багш 41
- Нягтлан бодогч 9
- Нярав 9
- Эмч 1
- Тогооч 18
- Үйлчлэгч 6
- Манаач , жижүүр 15
- Сантехникч 1,
- Бусад албан тушаалд 8 хүн тус тус ажиллаж байна.

8.3 2014-2015 оны хичээлийн жилд 362 хүүхэд 1-р ангид элсэн орсон байна. Насны ангиллаар нь авч үзвэл 5 настай 31, 6 настай 322, 7 настай 7 хүүхэд , 8 настай 2 хүүхэд байлаа.

ЕБС-д 268 ажиллагсад үүнээс 219 нь буюу 81.7 хувь нь эмэгтэй байна.

Албан тушаалаар нь авч үзвэл:

- Захирал 5
- Сургалтын менежер 9
- Нийгмийн ажилтан 4
- Үндсэн багш 171
- Цагийн багш 1
- Байрны багш 3
- Нягтлан бодогч 5
- Нярав 5
- Архив бичиг хэрэг 5
- Номын санч 4

- Эмч 5
- Тогооч 4
- Сантехникч 2
- Цахилгаанчин 1
- Мужаан 1
- Үйлчлэгч 22
- Манаач, жижүүр 21 хүн тус тус ажиллаж байна.

171 үндсэн багш ажиллаж байгаа ба нэг багшид ногдох суралцагчийн тоо 17.8 байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал: Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхдийн тоо 10.4 хувиар, Ерөнхий боловсролын сургуульд суралцагчдын тоо 1.8 хувиар, нэг багшид ногдох суралцагч 0.1 хувиар тус тус нэмэгдсэн байна.

9. ЭРҮҮЛ МЭНД ,ЭМ ТАРИА

9.1 Аймгийн эрүүл мэндийн газрын мэдээгээр 2014 оны байдлаар аймгийн хэмжээнд 446 эх амаржсан байна. Амьд төрсөн хүүхдийн тоо 449 байгаагаас 53.0 хувь нь хүү, 47.0 хувь нь охин байна.

Нийт төрөлтийн 0.7 хувь амьгүй төрөлт эзэлж, 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 ба 1000 амьд төрөлтөд 6.1 ноогдож аймгийн төвд 2, хөдөө багт 1 хүүхэд эндсэн. Амьгүй төрөлт 3, гэрийн төрөлт 1 бүртгэгдсэн. Эхийн нас баралт, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл бүртгэгдээгүй.

2014 онд аймгийн хэмжээнд тав хүртэлх насны хүүхдийн өсөлт хөгжлийн хяналтанд 1037 хүүхэд хамрагдаж тураалтай, өсөлтийн хоцрогдолтой хүүхэд 6.7 хувь, 14.9 хувьд А аминдэм, 52.2 хувьд нь Д аминдэм, 2.6 хувьд олон найрлагт бичил тэжээлийн холимог өгсөн байна.

Үзүүлэлт	2013 он	2014 он
Төрсөн эх	478	466
Амьд төрсөн хүүхэд	479	449
Амьгүй төрөлт	2	3

Эмнэлгийн нас баралт	13	14
Хоног болоогүй нас баралт	7	7
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	7	3
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	7	0
Ор хоног	34009	40510
Эмчлэгдсэн өвчтөн	4449	5246
Амбулаторын үзлэг	37167	64886
Осол гэмтлийн дуудлага	580	456
Халдварт бус өвчин	3897	5213

10. ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭ, ҮНЭ

10.1 Бизнес ригестрийн сангийн бүртгэлээр худалдааны салбарт 52 аж ахуй нэгж бүртгэгдсэнээс ҮСХ-ны батлагдсан хүрээгээр худалдаа үйлчилгээний 13 аж ахуй нэгж байгууллага 2014 оны мэдээ тайланд хамрагдсан байна.

2014 оны мэдээллээр худалдааны салбарын орлого 74.1 тэрбум төгрөг, Тайлант хугацаанд борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 65.5 тэрбум төгрөгт хүрснийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт орлого 36.4 тэрбум буюу 49.1 хувиар, борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг 30.7 тэрбум төгрөг буюу 46.9 хувиар тус тус буурсан байна.

Тайлант онд хүрээнд хамрагдсан 13 нэгжид 168 хүн ажилласан байна.

10.2 Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өмнөх онтой харьцуулахад хүнсний мах гурилын үнийн өсөлт өндөр байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад гурил 50 төгрөг буюу 6.2 хувиар, махны үнийн хэлбэлзэл 200-300 төгрөгийн хооронд буюу ойролцоогоор 2.5 хувийн өсөлттэй байлаа. Цагаан будаа 8.7 хувиар, шингэн сүү 8,3 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Ноолуурын үнэ жилийн 3-7 сарын үед өндөр буюу 50000 - 85000 байсан бол бусад саруудад тогтмол буюу 20000-30000 төгрөгийн хооронд байна.

Шатахуун, түлшний үнэ өмнөх оны дунджаас 50 төг буюу 2.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна

дд	Барааны нэр	2013 он	2014 он	Жилийн дундаж өсөлт
		12-р сар	12-р сар	
1	Гурил 1-р зэрэг	750	800	6.2
2	Хонины мах /кг/	5500	5800	5.2
3	Үхрийн мах /кг/	7000	7000	0
4	Ямааны мах /кг/	4400	4500	2.2
5	Элсэн чихэр /кг/	1700	1700	0
6	Цагаан будаа /кг/	2300	2100	-8.7
7	Шингэн сүү /л /	1200	1100	-8.3
8	Ноолуур /кг/	55000	30000	-45.5
9	Ноолуур /хуучин/	50000	20000	-60.0
10	А-80	1450	1500	3.3
11	АИ-92	1710	1750	2.3
12	ДТ	1800	1850	2.7

11. ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээнд 12 сарын байдлаар 211 гэмт хэрэг бүртгэгдсэн ба үйлдэгдсэн гэмт хэргийн 106 нь буюу 50.2 хувь нь хүний амь бие эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг байлаа . Бүртгэгдсэн гэмт хэрэг өмнөх оны мөн үеэс 17.9 хувиар өссөн байна.

Гэмт хэрэгт холбогдогсод 201, үүний 91 нь буюу 45.3 хувь нь ажилгүй иргэдийн үйлдсэн гэмт хэрэг байна. Гэмт хэрэгт холбогдогсодыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 9.2 хувиар өссөн байна. .

Давхардсан тоогоор 1433 хүн эрүүлжигдэж, 234 жолооч эрхээ хасуулж , 215 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад эрүүлжигдсэн хүний тоо 7.0 хувиар , жолооны эрх хасуулсан хүний тоо 2.9 хувиар буурч, баривчлуулсан хүний тоо 1.9 хувиар өссөн үзүүлэлт гарлаа

Гэмт хэрэг зөрчлийг төрлөөр нь танилцуулбал:

дд	Гэмт хэргийн төрөл	Хэргийн тоо		Өсөлт бууралт	
		2013 он	2014 он	тоо	хувь
1	Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг	98	106	8	8.2
2	Хүүхэд гэр бүлийн нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэг	1	3	2	200.0
3	Иргэдийн улс төрийн болон эрх чөлөө	1	2	1	100.0
4	Өмчлөх эрхийн эсрэг	40	67	27	67.5
5	Байгал хамгаалах журмын эсрэг гэмт хэрэг	0	1	1	1 нэгж
6	Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	8	6	-2	-25.0
7	Хүн амын эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг	3	4	1	33.3
8	Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	22	17	-5	-22.7
9	Захиргааны журмын эсрэг гэмт хэрэг	3	0	-3	-100.0
10	Шүүн таслах ажиллагааны эсрэг гэмт хэрэг	2	0	-2	-100.0
11	Албан тушаалын гэмт хэрэг	1	4	3	300.0
12	Цэргийн албаны эсрэг гэмт хэрэг	0	1	1	1 нэгж
	Бүгд	179	211	32	17.9

Гэмт хэрэг илрүүлэлт жилийн эцсийн байдлаар 62.0 хувьтай байна. Энэ онд онц хүнд гэмт хэрэг 1, хүнд гэмт хэрэг 9, хүндэвтэр гэмт хэрэг 63, хөнгөн гэмт хэрэг 138 бүртгэгдсэн байна.

Гэмт хэргээс учирсан хохирол 329.9 сая төгрөг, нөхөн төлүүлсэн нь 78.7 сая төгрөгт хүрсэн байна.

12. ЦАГ УУР

2014 онд агаарын температур өвлийн сард дундажаар 15 градус хүйтэн, хавар сард дундажаар 6 градус дулаан, зуны сард дундажаар 20 градус дулаан, намрын сард дундажаар 4 градус дулаан байсан.

Энэ жилийг 2013 онтой харьцуулбал бүх улиралдаа 2...3 градус орчмоор дулаан байсан байна.

Хөрсний температур өвлийн сард дундажаар 17 градус хүйтэн, хавар сард дундажаар 9 градус дулаан, зуны сард дундажаар 25 градус дулаан, намрын сард дундажаар 5 градус дулаан байсан.

2014 оныг өмнөх жилтэй харьцуулбал өвөл бага зэрэг хүйтэн, хавар бага зэрэг дулаан, зун, намартаа өмнөх жилтэй ойролцоо байсан байна.

Салхи дундажаар 3-8 м/сек байсан. Хавар зарим үед салхи хамгийн ихдээ 16 м/сек хүр ширүүссэн байна. Мөн 7-р сард 16 м/сек хүрч ширүүссэн. Бусад хугацаанд хамгийн ихдээ 10 м/сек хүрсэн байна.

Өмнөх жилийг бодвол салхи багатай байсан.

2014 онд нийт 98.4 мм хур тунадас унасан ба хүйтний улиралд 8.9 мм, дулааны улиралд 89.5 мм бороо орсон байна. 2013 оныг бодвол жил орсон хур тунадас бага байна.

13. ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГАА

Говьсүмбэр аймаг 2014 онд Улсын төсвийн болон аймаг, сумдын Орон нутгийн хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар нийт 128 төсөл, арга хэмжээг 8635.3 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Үүнд: Нээлттэй тендер шалгаруулалтын журмаар 46, Харьцуулалтын журмаар 52, Шууд худалдан авах журмаар 23, Олон нийтийн оролцоотой 7 төсөл, арга хэмжээ хамрагдаж байна.

Д д	Хөрөнгө оруулалт	Сонгон шалгаруулалт				Төлөвлөгдсөн бараа үйлчилгээ	Зарлагдсан тендер	Төлөвлөсөн төсөв /сая төг /	Гэрээлэгдсэн төсөв / ая төг/
		Нээлттэй тендер	Харьцуулалтын журмаар	Шууд худалдан авалт	Олон нийтийн оролцоотой				
1	Улсын төсвийн	8	1			9	9	1386.3	1239.4
2	Аймгийн орон нутгийн хөгжил сан	1 2	14			26	26	2621.2	2461.9
3	Сумдын ЗДТГ- н захиалгаар	8				8	8	2028.6	1886.7
4	Сүмбэр сумын орон нутаг сан	5	14	8		27	26	945.1	861.4
5	Баянтал сумын орон нутаг сан	4	10	4	4	22	22	556.6	521.0
6	Шивээговь сумын орон нутаг сан	9	5	11	3	28	24	836.5	631.1
7	Байгал хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал		7			7	7	192.0	185.0
8	Авто замын сан		1			1	1	69.0	68.0
7	Нийт	46	52	23	7	128	123	8635.3	7854.5